

# APU COMPANY

Absolute. Pure. Unique.



## **АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Улаанбаатар хот, 2023 он

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА

\_\_\_\_\_ / Б.БУЯННЭМЭХ /

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

АПУ ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

\_\_\_\_\_ / Ц. ЭРДЭНЭБИЛЭГ /

**АПУ ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**/ РЕГИСТРИЙН ДУГААР: 2702673/**

ХЯНАСАН:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН

ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН \_\_\_\_\_ / П.ШИНЭЦЭЦЭГ /

БОЛОВСРУУЛСАН:

АПУ ХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧИН

ТОГТОЛЦОО ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН \_\_\_\_\_ / Б.НОМИНЖАРГАЛ /

**2023 он**

## АГУУЛГА

<b>НЭГ. АПУ ХК – ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</b> .....	3
1.1 Төслийн товч танилцуулга .....	3
1.2 АПУ ХК – ийн Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга .....	5
1.3 Орчны хяналт шинжилгээ.....	6
1.3.1 Хөрсний бохирдол .....	6
1.3.2 Орчны агаарын чанар .....	7
1.3.3 Усны чанар.....	8
<b>ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b> .....	13
2.1 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ .....	13
<b>ГУРАВ. 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ</b> 16	
3.1 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө.....	16
3.2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө .....	19
3.2.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр .....	22
3.3 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....	24
3.4 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	26
<b>2024 оны байгаль орчны менежментийн</b> .....	29
<b>төлөвлөгөөний нийт зардал</b> .....	29
<b>ТАВ. ДҮГНЭЛТ</b> .....	29

## НЭГ. АПУ ХК – ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


### 1.1 Төслийн товч танилцуулга

<b>Төслийн нэр:</b>	Архи, пиво, ус ундааны үйлдвэрлэл
<b>Төсөл хэрэгжүүлэгч:</b>	АПУ ХК
<b>Хэлбэр:</b>	Нээлттэй хувьцаат компани
<b>Хувьцаа эзэмшигчдийн тоо:</b>	4870
<b>Нийт хувьцааны тоо ширхэг:</b>	1.604.181.553 ширхэг
<b>Улсын бүртгэлийн дугаар:</b>	9010001005
<b>Регистрийн дугаар:</b>	2702673
<b>Холбоо барих утас:</b>	91111788
<b>Байршил:</b>	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 19 – р хороо, Чингисийн өргөн чөлөө 48, АПУ ХК - ний байр
<b>Төслийн зорилго:</b>	Орчин үеийн дэвшилтэт техник, технологи ашиглан үндэсний болон олон улсын стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн хэрэглэгчдийг хангах, импортын бүтээгдэхүүнийг орлож, дотоодын зах зээлийг дотоодын бүтээгдэхүүнээр хангахад чиглэсэн Монгол улсын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, бүтээгдэхүүнээ олон улсын зах зээлд гаргах, үйлдвэрлэлд хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад чиглэсэн байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэрэг зорилго, ач холбогдолтой.
<b>Үйл ажиллагааны чиглэл</b>	Архины үйлдвэрлэл Спиртийн үйлдвэрлэл Пивоны үйлдвэрлэл Ус, ундаа, жүүс үйлдвэрлэл Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл Гадаад худалдаа Хүнсний бөөний төв болон жижиглэнгийн худалдаа Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх
<b>Ажиллах хүч:</b>	854
<b>Ус, дулаан, цахилгаан, уурын хангамж</b>	Төвийн шугам сүлжээнд холбогдсон.
<b>Татвар төлөлт:</b>	МУ нэгдсэн төсвийн орлого 1.6% буюу 129 тэрбум/ төг Онцгой албан татварын орлого 18.3% буюу 95 тэрбум/төг НӨАТ орлого 1.3% буюу 20 тэрбум/төг
<b>Дотоодын зах зээлд бүтээгдэхүүний эзлэх хувь</b>	Архины зах зээлийн 49-51% Пивоны зах зээлийн 61-63% Хийжүүлсэн ундааны зах зээлийн 3% Цэвэр усны зах зээлийн 5-6%-ийг тус тус хангаж байна.



Зураг 1. Үйлдвэрийн байршил

АПУ ХК нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 19 – р хорооны нутаг дэвсгэр Чингисийн өргөн чөлөөнд байрладаг ба ус, ундаа, шар айраг, архи зэрэг шингэн хүнсний үйлдвэрлэлээр үйл ажиллагаа эрхэлдэг. Үйлдвэрийн бүтэц зохион байгуулалтын хувьд АПУ ХК нь Архины үйлдвэр, Пивоны үйлдвэр, Лонх угаах үйлдвэр (архи, пивоны лонх угаах хэсэг), Савлах үйлдвэр (ус, ундаа, ПЭТ, лонх, лаазанд савлах хэсэг), бэлэн бүтээгдэхүүн болон түүхий эд, туслах материалын агуулах гэсэн үйлдвэрийн хэсгүүдтэй.




Зураг 2. Үйлдвэрийн зохион байгуулалтын бүдүүвч

## 1.2 АПУ ХК – ийн Байгаль орчны менежментийн тогтолцооны танилцуулга

АПУ хувьцаат компанийн бодлого, хэрэгжүүлж буй үйл ажиллагаанууд нь ‘Тогтвортой хөгжил’-ийн үндсэн суурь зарчим болох НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧИН тэнцвэртэй хөгжлийг ханган нийгэм, эдийн засаг, хүн баялагт үнэ цэн бүтээхэд чиглэн ажилладаг билээ. Байгаль орчин тогтвортой хөгжлийн стратеги нь АПУ компанийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг ба бүхий л үйлдвэр үйл ажиллагааны туршид байгаль орчны сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, аюултай материал, ус, эрчим хүч болон бусад байгалийн нөөцийн хэрэглээг хэмнэх, үүсэх хог хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх зэрэг зарчимуудыг баримтлан ажилласаар байна. Иймд 2021 оны тогтвортой хөгжлийн стратегийн хүрээнд “Илүү сайхан дэлхийг цогцлооё” уриан доор үйлдвэрлэл үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийг хэрэгжүүлэн ажиллалаа. Байгаль орчин тогтвортой хөгжлийн хүрээнд бид 2021 онд байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, хэрэгжүүлэлтийг нэмэгдүүлэх, хог хаягдлын менежментийг сайжруулах, байгалийн нөөцийн хэмнэлтийг бий болгох зэрэг үндсэн 3 зорилтын хүрээнд ажилласан билээ.

1. Байгаль орчны менежментийн тогтолцоог сайжруулах, тогтвортой хөгжүүлэх ажлын хүрээнд нийт үйлдвэр нэгж хэсгүүдэд байгаль орчны дэд багуудыг шинэчлэн байгуулж ажилчид гишүүдийн оролцоог нэмэгдүүлэн ISO 14001 БОМТ –ны хэрэгжилтийг хангуулахад хамтран ажилладаг боллоо.



Зураг 3. Үйлдвэр, алба нэгжүүд дахь байгаль орчны баг бүрэлдэхүүн



Үүний зэрэгцээ эрчим хүчний баг байгуулагдан эрчим хүчний хэмнэлтийн хөтөлбөр болон эрчим хүчний аудитыг хэрэгжүүлэн эхлүүлсэн байна.

2. Хог хаягдлын менежментийн хүрээнд хог хаягдлын 3R стратегийг үйлдвэр нэгж хэсгүүдэд хэрэгжүүлэн хог хаягдлын цэгүүдийг 5S зарчмын дагуу сайжруулан хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлж байна. Түүнчлэн үйлдвэрлэлээс гарч буй бүх төрлийн хатуу хог хаягдлын хэмжээг бууруулах, ландфиллд хаягдах хаягдлыг багасгах, дахивар хог хаягдлаа эргүүлэн ашиглах, дахин боловсруулахад чиглэн ажиллаж нийт хог хаягдлын хэмжээгээ энэ үеийн өмнөх онтой харьцуулахд 30% -иар бууруулж дахин боловсруулах компаниудын түншлэлээ нэмэгдүүллээ. Тухайлбал аюултай болон химийн хорт бодисын сав баглаа боодлыг дахин боловсруулах үйлдвэр Түмэн Эгшиг ХХК болон хаягдал шилээ Шинэ шил ХХК, хаягдал гялгах уутаа Мултипак ХХК зэрэг компаниудтай хамтран ажиллаж дахивар хаягдлуудаа тус тус нийлүүлсээр байна.

### 1.3 Орчны хяналт шинжилгээ

#### 1.3.1 Хөрсний бохирдол

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2023 оны 06 -р сард үйлдвэрийн гадна талбайгаас хөрсний дээжийг авч, “Нарт Шүүн Консалтинг” ХХК-ний Хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.



Зураг 4. Хөрсний дээж авсан цэг /үйлдвэрийн хашаанаас авсан хөрсний дээж/

ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД								
Дээж авсан гүн, см	PH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO <sub>3</sub> , %	NO <sub>3</sub> , мг/100г	Солилцох сууриуд, мг-эквю/100г	Шим тэжээлийн элементүүд мг/100г

							Ca <sup>+2</sup>	Mg <sup>+2</sup>	P <sub>2</sub> O <sub>5</sub>	K <sub>2</sub> O
Дээж 1.										
0-20	8.2	0.069	0.169	3.75	0.96	0.64	26	11	7.7	31

Хүснэгт 1. Хөрсний химийн үндсэн үзүүлэлтийн шинжилгээний хариу

ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН							
Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1							
0-20	12.8	43.7	21.6	8.4	8.2	5.3	21.9

Хүснэгт 2. Хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний хариу

ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД							
Дээж авсан газар, газарзүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1	0-20	44.5	21	0	76.4	42.2	15.1
<b>Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5650:2019</b>							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

\*харгалзах түвшин


Хүснэгт 3. Хөрсний хүнд металлын үзүүлэлтийн шинжилгээний хариу

Шинжилгээний үр дүнгээс харахад харгалзах үзүүлэлт нь MNS 5650 : 2019 стандарттай харьцуулахад хөрсөнд агуулагдах хүнд металлын хэмжээ стандарт хэмжээнээс даваагүй үзүүлэлттэй гарсан байна.

### 1.3.2 Орчны агаарын чанар

2023 оны 6-р сард нэрийн архины үйлдвэрийн гадна, будаа хүлээн авах хэсэгээс азотын давхар исэл, хүхэрлэг хий, нийт тоосны хэмжилтийг хийж “Ногоон Титэм” ХХК-ийн итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. Шинжилгээний дүнгээс харахад үйлдвэр гадна агаар дахь NO<sub>2</sub>, SO<sub>2</sub> нийт тоосны агууламж “Агаарын чанарын стандарт” MNS 4585:2016 дотоод орчны агаар Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин MNS 4990:2000 стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.





Зураг 5. Агаарын чанарын шинжилгээ

№	Сорьц авсан цэг	Хүхэрлэг хий (SO <sub>2</sub> ), мг/м <sup>3</sup>	Азотын давхар исэл (NO <sub>2</sub> ), мг/м <sup>3</sup>
<b>Агаарын чанарын стандарт MNS 4585:2016</b> <i>/20 минутын дундаж/</i>		<b>450 мкг/м<sup>3</sup></b>	<b>200 мкг/м<sup>3</sup></b>
1	Архины үйлдвэрийн гадна /47.8975916, 106.9047832/	36.80 мкг/м <sup>3</sup>	27.91 мкг/м <sup>3</sup>
2	Будаа хүлээн авах хэсгийн гадаа /47.8987274, 106.9030794/	<20мкг/м <sup>3</sup>	10.77 мкг/м <sup>3</sup>

Хүснэгт 4. Гадна агаарын чанарын хэмжилтийн дүн

### 1.3.3 Усны чанар

Төвлөрсөн төвийн шугамын усны дээжинд АПУ ХК-ийн өөрийн итгэмжлэгдсэн төв лабораторид сард бүр чанарын шинжилгээ хийдэг. АПУ ХК нь “Архи пиво ундааны үйлдвэрлэл, химийн бодисын агуулах” төслийн БОННУ-ний нэмэлт тодотголын тайлангийн ажлын хүрээнд 2023 оны 12 сарын 5-ны өдөр үйлдвэрийн хаягдал ус болон ундны уснаас дээж аван “Хан Лаб” итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн ба дараах хүснэгтэ сорилтын тайланг харуулав.

Хүснэгт 5. Усны чанарын шинжилгээний мэдээ



**ХАНЛАБ ХХК**  
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзандамба  
гудамж 34/6 тоот, Хан Рагшаан компанийн байр  
Утас: 70109968, 99995316  
<http://www.khanlab.mn>



**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: И ЭЙЧ ЭС ЭМ ХХК

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,  
ТОО

Ус, 2

ТӨСЛИЙН НЭР: Апу ХХК, Архи пиво ус ундааны үйлдвэр

ЗАХИАЛГА №: 2023/2153

ХҮЛЭЭН АВСАН ОГНОО: 2023.12.05

ШИНЖИЛСЭН ОГНОО: 2023.12.19

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ХУУДАСНЫ ТОО: 2

Сертификт үр дүн зөвхөн тухайн дэвжид хамаарна.  
Дэвжлэлтийн талварх асуудлыг манай лаборатори хариуцахгүй болно.

Чанарын менежер:



Д.Пүрэвжаргал

*Хамтран амжилтасан танд талархнаа.*

ЗАХИАЛГА №: 2023/2153

ДЭЭЖИЙН ДУГААР: Усны ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-24377

№	ЭЛЕМЕНТ	НӨГЖ	ШИЖИЛГЭЭНИЙ ДҮН	ЭВШӨӨРӨГ ДӨХ	СТАНДАРТ АРГА
				ХЭМЖЭЭ MNS 0900:2018	
1	pH	-	6.77	6.5-8.5	MNS ISO 10523:2001
2	Кали (K <sup>+</sup> )	мг/л	0.92	-	MNS 5465:2005
3	Натри (Na <sup>+</sup> )	мг/л	8.00	200.0	
4	Кальци (Ca <sup>2+</sup> )	мг/л	42.87	100.0	MNS ISO 2572:1999
5	Магни (Mg <sup>2+</sup> )	мг/л	3.89	30.00	
6	Аммоний (NH <sub>4</sub> <sup>+</sup> )	мг/л	<0.10	1.50	MNS ISO 7150-1:2006
7	Хлорид (Cl <sup>-</sup> )	мг/л	27.23	350.0	MNS ISO 9297:2005
8	Сулфат (SO <sub>4</sub> <sup>2-</sup> )	мг/л	75.92	500.0	MNS 3652-4:1984 MNS ISO 11885:2011
9	Нитрат (NO <sub>3</sub> <sup>-</sup> )	мг/л	<0.05	1.00	MNS 4431:2005
10	Нитрит (NO <sub>2</sub> <sup>-</sup> )	мг/л	0.64	50.00	MNS ISO 7890-3:2001
11	Карбонат (CO <sub>3</sub> <sup>2-</sup> )	мг/л	<1.50	-	MNS ISO 9963-1:2005
12	Гидрокарбонат (HCO <sub>3</sub> <sup>2-</sup> )	мг/л	30.51	-	
13	Нийт харуулагч	мг-экв/л	2.46	7.00	
14	Хуурай үлдэгдэл, TDS	мг/л	188.0	1000	MNS 4423:1997
15	Цахуурын хүчид, H <sub>2</sub> SiO <sub>3</sub>	мг/л	12.24	-	
16	Исэлтэй чанар KMnO <sub>4</sub>	мгO <sub>2</sub> /л	2.08	-	MNS ISO 4889:1999
17	Фосфат, PO <sub>4</sub> <sup>3-</sup>	мг/л	<0.05	3.5	MNS ISO 6878:2001
18	Фтор, F	мг/л	0.64	0.7-1.5	MNS ISO10359-1:2002
19	Хүхэрхустөрөгч, H <sub>2</sub> S <sub>g</sub>	мг/л	<0.10	0.1	
20	Чөлөөт хлорид, Cl <sub>free</sub>	мг/л	<0.10	0.2-0.3	MNS ISO 7393-1:2001
21	Булингар	NTU	<10.0	1.5	
22	Мөнгө, Ag	мг/л	<0.01	0.1	
23	Холгоцогчлоо, Al	мг/л	<0.025	0.50	
24	Мышьяк, As	мг/л	<0.01	0.01	
25	Бор, B	мг/л	0.10	2.40	
26	Барн, Ba	мг/л	0.02	0.70	
27	Берилли, Be	мг/л	<0.001	0.0002	
28	Кадмий, Cd	мг/л	<0.005	0.005	
29	Кобальт, Co	мг/л	<0.001	-	
30	Хром, Cr	мг/л	<0.005	0.05	
31	Эс, Cu	мг/л	<0.02	2.0	MNS (ISO) 11885:2011
32	Төмөр, Fe	мг/л	0.05	0.3	
33	Магний, Mn	мг/л	<0.01	0.1	
34	Молибден, Mo	мг/л	0.02	0.07	
35	Никель, Ni	мг/л	<0.005	0.02	
36	Хартуулагч, Pb	мг/л	<0.01	0.01	
37	Сурьма, Sb	мг/л	<0.01	0.02	
38	Селен, Se	мг/л	<0.01	0.04	
39	Стронци, Sr	мг/л	0.36	2.00	
40	Уран, U	мг/л	<0.10	0.03	
41	Цайр, Zn	мг/л	0.01	5.0	
42	Цианид, CN <sub>free</sub>	мг/л	<0.002	0.01	MNS ISO 6703(CD):2005
43	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.001	EPA Method 7473

Шинжлэхийн дүгнэлт: Шинжилгээнд ирүүлсэн усны чанар - Монгол улсад мөрдөгддөг буй "Усны усныг MNS 0900:2018 стандарт"-ын шаардлагыг хангаж байна.



Хуудас 2-1

ЗАХИАЛГА №: 2023/2153

ДЭЭЖИЙН ДУГААР: Бөхир ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-24378

№	ЭЛЕМЕНТ	НЭГЖ	ШИВЖИЛГЭСЭНИЙ ДҮН	ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ /MNS 6561:2015/	СТАНДАРТ АРГА
1	Температур	°C	22.6	30.0	-
2	pH	-	6.31	6-9	MNS ISO 10523:2001
3	Аммон, NH <sub>4</sub> <sup>+</sup>	мг/л	64.00	15.0	MNS ISO 7150-1:2006
4	Хлорид, (Cl)	мг/л	121.2	1000	MNS ISO 9297:2005
5	Сульфат (SO <sub>4</sub> <sup>2-</sup> )	мг/л	109.9	700	MNS 3652.4:1984 MNS ISO 11885:2011
6	Уяйуур бодис, TSS	мг/л	<3.0	400	
7	Химийн хэрэгцээг хүчилжрөгч, COD	мгO <sub>2</sub> /л	92.00	800	MNS ISO 6060:2001
8	Биологийн хэрэгцээг хүчилжрөгч, BOD	мгO <sub>2</sub> /л	36.27	400	MNS ISO 5815:2001
9	Хүүхэргүстөрөгч, H <sub>2</sub> S	мг/л	<0.10	5.0	
10	Хөнгөнцагаан, Al	мг/л	0.08	0.50	
11	Мысгалак, As	мг/л	<0.01	0.10	
12	Эс, Cu	мг/л	0.14	1.0	
13	Кадм, Cd	мг/л	<0.005	0.05	
14	Кобальт, Co	мг/л	0.003	0.10	
15	Төмөр, Fe	мг/л	0.24	3.0	MNS (ISO) 11885:2011
16	Никель, Ni	мг/л	0.005	0.02	
17	Селен, Se	мг/л	<0.01	0.10	
18	Хартуугаага, Pb	мг/л	<0.01	0.2	
19	Фосфор, P	мг/л	1.76	1.5	
20	Хром, Cr	мг/л	0.005	0.01	
21	Цайр, Zn	мг/л	0.11	5.0	
22	Хром, Cr (VI)	мг/л	<0.05	0.05	MNS ISO 11083:2001
23	Цианид, CN <sub>total</sub>	мг/л	<0.002	0.10	MNS ISO 6703 (FC) 2006
24	Мөнгөн ус, Hg	мг/л	<0.001	0.005	EPA Method 7473 Хууль 2-2





**ХАНЛАБ ХХК**  
Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 17 р хороо, Богд Жавзансламба  
гудамж 34/6 тоот, Хан Рагцан компанийн байр  
Утас: 70109968, 99995316  
<http://www.khanlab.mn>



**ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН**

ЗАХИАЛГА №: МБ 2023/484

ДЭЭЖИЙН ТӨРӨЛ,  
ТОО:

Ус, 1

ЗАХИАЛАГЧИЙН НЭР: И ЭЙЧ ЭС ЭМ ХХК

/ТӨСЛИЙН НЭР: АПУ ХК АРХИ ПИВО УС УНДААНЫ ҮЙЛДВЭР/

ДЭЭЖИЙН ДУГААР: Ундны ус

ЛАБОРАТОРИЙН ДУГААР: Л-1990

ДЭЭЖИЙН ХЭМЖЭЭ, мл: 500

№	ҮЗҮҮЛЭЛТ	СТАНДАРТ АРГА	НЭГЖ	ЗӨВШӨӨРӨГДӨХ ДЭЭД ХЭМЖЭЭ MNS 0900:2018	ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН
1	Бактерийн сөрөгсий тоо	MNS ISO 6272:1998	1 мл-д	100	1
2	Халуунд гэхээртэй гэдэсний бүлгийн илэгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрээгүй	илрээгүй
3	Коллиформ гэдэсний бүлгийн илэгийн тоо	MNS ISO 9308-1:1998	100 мл-д	илрээгүй	илрээгүй
4	Гэдэсний бүлгийн эмгэг төрөгч илэ	MNS ISO 19250:2017	25 мл-д	илрээгүй	илрээгүй
5	<i>Clostridium perfringens</i>	MNS ISO 6461-2:1998	100 мл-д	илрээгүй	илрээгүй

Чанарын менежер

Д.Пүрэвжаргал

Сэрэмтэн үр дүн өгөгжөөг тусгай дүгнэлт хийж өгөхөд  
Дэлхийн талард агуулагдсан махны лаборатори хариуцажгүй болно.

ДЭЭЖИЛСЭН ОГНОО: 2023.12.05

ШИНЖИЛГЭЭ ЭХЭЛСЭН ОГНОО: 2023.12.05

ДЭЭЖ БОЛОВСРУУЛАЛТ: хийгдээгүй

ШИНЖИЛГЭЭ ДРУССАН ОГНОО: 2023.12.13

ХУУДАСНЫ ТОО: 1

*Хамтран ажилласан танд талархна.*

Хуудас 1-1



## ХОЁР. ҮЙЛДВЭРИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

### 2.1 Болзошгүй нөлөөллийн үнэлгээ

“Цагаан Уулын Оргил” ХХК нь 2019 онд АПУ ХК - ийн архи, пиво, савлах үйлдвэрийн төслийн баримт бичиг, зураг төсөл, бүртгэл тэмдэглэл, үйлдвэрийн орчинд хийсэн хэмжилтийн үр дүн, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол доройтлын түвшин, химийн бодисын эрсдлийн үнэлгээ зэрэгт үндэслэн үйлдвэрийг 4 хэсэгт хуваан, хэсэг тус бүрт үнэлгээ хийснийг энэ бүлэгт нэгтгэн магадлан жагсаах буюу хяналтын болон асуулгын хуудасны арга, математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон.

	Хэлбэр		Хугацаа			Чиглэл		Эрчим		
	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино	Урт	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд	Сул
<b>1. Байгалийн нөөц ашиглалт, байгаль орчны чанарын асуудал</b>										
1	Уур амьсгалын өөрчлөлт	-			-		-			-
2	Усны нөөц ашиглах	-			-		-		-	
3	Газрын доорхи усны нөөц хомсдох	-			-		-			-
4	Эрчим хүч хэрэглэх	х			х		х			Х
5	Ургамлын нөмрөгт нөлөөлөх	-		-			-			-
6	Гадаргын усны чанарт нөлөөлөх		-		-		-			-
7	Агаарын чанарт нөлөөлөх		-		-		-			-
8	Хөрсний бохирдол үүсэх	-			-		-			-
9	Химийн бодис хөрсөнд нэвчиж, хөрс ба гүний усыг бохирдуулах		-		-		-			-
10	Дуу чимээ, доргио чичиргээний нөлөө үүсэх	-			-		-			-
11	Хатуу хог хаягдал үүсэх	-			-		-		-	
12	Шингэн хог хаягдал үүсэх	-			-		-		-	
13	Химийн бодисын хортой, аюултай хог хаягдал үүсэх	-			-		-			-
<b>2. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>										
14	Нийгэм, эдийн засагт эерэгээр нөлөөлөх /бүтээгдэхүүн үйлдвэрлэл есөх/	+			+		+		+	
15	Байгалийн нөөц ашигласны төлбөр, хариуцлага	+			+		+		+	

16	Харьяа орон нутгийн орлого нэмэгдэх	+				+	+			+	
17	Харьяа орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	+				+	+			+	
18	Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөх	+				+	+			+	
19	Ажлын байр нэмэгдэх	+				+	+			+	
<b>3. Бусад нөлөөлөл</b>											
20	Үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх		-		-		-				-
21	Хүчтэй салхи, түймэр, аюул осол		-		-		-			-	
Дүн, тоогоор		16	6	-	4	17	8	13	-	10	11
Дүн, хувиар		76	24	-	19	81	38	62	-	48	52

Хүснэгт 1. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим

(+) Эерэг нөлөөтэй, (-) Сөрөг нөлөөтэй, (x) Ямар нэг эерэг, сөрөг нөлөөгүй

### Нөлөөллийн үр дүн:

Төслөөс байгаль орчин, нийгэм, эдийн засагт шууд байдлаар үзүүлэх нөлөөллийн 31.2% нь ямар нэгэн эерэг, сөрөг нөлөөгүй, 18.7% нь эерэг, 50% нь сөрөг нөлөөлөлтэй байна. Үйлдвэрийн үйл ажиллагааны явцад усны нөөц, химийн бодис, бүтээгдэхүүн ашиглах, хатуу шингэн хог хаягдал, дуу чимээ, доргио чичиргээ үүсэх зэрэг нь сул эрчимтэйгээр урт хугацаанд, харин гэнэтийн осол аваар, эрсдэл, гал түймэр, үер, хүчтэй салхи зэрэг нь дунд эрчимтэйгээр богино хугацаанд буцалтгүйгээр шууд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийн хувьд “АПУ” ХК нь жилд ойролцоогоор Монгол улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6% буюу 129 тэрбум.төг, Онцгой албан татварын орлого 18.3% буюу 95 тэрбум.төг, НӨАТ орлого 1.3% буюу 20тэрбум.төг, Гаалийн татварт 3.7 тэрбум.төг, ААНОАТ-т 4.8 тэрбум.төг, бусад татварт 4.9 тэрбум төгрөгийг дангаараа бүрдүүлдэг тул дунд эрчимтэйгээр урт хугацаанд шууд хэлбэрээр эерэгээр буцаж нөлөөлнө.

Харин орон нутагт физик өөрчлөлт гарах, усны нөөц хомсдох, байгалийн дагалдах нөөц баялаг хомсдох, орчны агаарын чанар зэрэгт ямар нэгэн эерэг, сөрөг нөлөө үзүүлэхгүй

Экосистемийн бүрэлдэхүүн хэсэг		Нөлөөллийн хүчин зүйлүүд								
		Архины үйлдвэр	Пивоны үйлдвэр	Савлах үйлдвэр	Лонх угаах үйлдвэр	Түүхий эдийн агуулах	Бэлэн бүтээгдэхүүний агуулах	Лаборатори	Хог хаягдлын цэг	
		A1	A2	A3	A4	A5	A6	A7	A8	
Агаар	Агаарт бохирдуулагч бодис ялгаруулах	B1	10	9	10	10	10	10	10	9
	Дуу чимээ, доргио чичиргээ үүсгэх	B2	7	10	7	9	10	10	10	10
	Агаарт үнэрийн бохирдол үүсгэх	B3	10	8	10	10	10	10	10	8

	Цахилгаан соронзон цацраг үүсгэх	B4	10	10	8	10	10	10	10	10
Ус	Усны нөөц ашиглах	B5	8	8	8	6	10	10	10	10
	Усны нөөцийн хомсдол үүсгэх	B6	9	9	9	8	10	10	10	10
	Усны бохирдол үүсгэх	B7	8	8	8	6	10	10	10	10
Хөрс	Хөрсөн бүрхэвч эвдрэх	B8	10	10	10	10	8	8	10	8
	Хөрс бохирдуулах	B9	10	10	10	10	8	10	10	8
	Хөрс доройтох, цөлжих	B10	10	10	10	10	10	10	10	10
Ургамал	Ургамлан нөмрөг, ой мод өртөх	B11	10	10	10	10	9	10	10	9
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйл өртөх	B12	9	9	10	10	10	10	10	10
Амьтан	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах	B13	10	10	10	10	10	10	10	10
	Ховор, нэн ховор амьтан өртөх	B14	10	10	10	10	10	10	10	10
	<b>Дүн</b>		131	131	130	129	135	138	137	132
	Сөрөг нөлөөгүй 9-10	Хамгийн их анхаарал татаж буй асуудлууд: Дуу чимээ Усны бохирдол Усны нөөц ашиглах								
	Сөрөг нөлөө бага 7-8									
	Сөрөг нөлөө дунд 5-6									
	Сөрөг нөлөө их 3-4									
	Сөрөг нөлөө маш их 1-2									

Хүснэгт 2. Нөлөөллийн үнэлгээний матриц

Үр дүн: Байесын шалгуураар үнэлсэн нөлөөллийн матрицын үр дүнг нөлөөллийн хүчин зүйлсээр дараалуулбал  $A4 > A3 > A2 > A1 > A9 > A5 > A8 > A7$  гэсэн дарааллаар үнэлгээний жин эзэлж байна. Эндээс харахад хамгийн их анхаарал татаж буй асуудлууд болох үүсэх хатуу хог хаягдлын хэмжээ, ашиглаж байгаа цэвэр усны хэмжээ, хаягдал усны чанар, дуу чимээний үзүүлэлтүүдээр хамгийн бага оноо авч байгаа үйлдвэрийн хэсгүүдэд лонх угаах, савлах, архи-пивоны үйлдвэрүүд орж байна. Харин лаборатори болон аюултай хог хаягдлын цэг зэрэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд болзошгүй эрсдэлийн эх үүсвэр болох боловч экосистемд нийтэд нь нөлөөлөх байдал бага байна.

## ГУРАВ. 2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Бид шингэн хүнсний салбарын тэргүүлэгч компанийн хувьд үйлдвэрлэл, ханган нийлүүлэлтийн сүлжээндээ өөрсдийн бэлтгэн нийлүүлэгч, харилцагчдаас байгаль орчны талаар илүү хариуцлагатай бодлого баримтлан хамтдаа харилцан туршлагаа солилцон тогтвортой хөгжихийг уриалан хамтран ажиллаж байна. Бид 2024 онд НҮБ – аас баталсан дэлхийн улс орнууд бүх нийтээр дэмжин хүн бүрт хөгжил цэцэглэлтийг хүртээмжтэй байлгах, ядуурлыг бууруулах, эх дэлхийгээ хамгаалахыг зорьж буй тогтвортой хөгжлийн 17 зорилтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэн ажиллана. Бидний зорилго бол эх дэлхийдээ үзүүлэх аливаа сөрөг нөлөөллүүдийг хязгаарлаж, нийгэм, эдийн засагт оруулах эерэг хувь нэмрийг нэмэгдүүлэх юм. Үүний дотор байгаль орчин тогтвортой хөгжлийн хувьд нөөцийн үр ашигтай менежментэнд тулгуурлан байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эрхэлж тогтвортой нийгмийг бий болгоход хувь нэмрээ оруулах байгаль орчны бодлого доор үйл ажиллагаагаа явуулна. Тайлангийн дараах хэсгүүдээс 2024 онд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй дэлгэрэнгүй танилцана уу.



АПУ ХК нь 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа 2019 онд “Цагаан уулын Оргил” ХХК-ийн боловсруулсан АПУ компанийн “Архи, пиво, ус, ундааны үйлдвэрлэл, химийн бодисын агуулах” төслийн Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэмэлт тодотгол тайлангаар тодорхойлогдсон төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалтаас гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

### 3.1 Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө

АПУ ХК-ийн Байгаль орчны дэд баг нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны (ХАБЭАБО) албанд харьяалагддаг ба байгалийн нөөцийн менежмент, түүний зохистой хэрэглээ, хог хаягдлын менежмент, хүрээлэн буй орчинд нөлөөлж болзошгүй эрсдэлийн менежмент, орчны хяналт шинжилгээ зэрэг чиглэлүүдэд үйл ажиллагаагаа явуулж Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох

дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг ханган ажиллуулах зорилготойгоор ажиллаж байна. Түүнчлэн АПУ ХК нь 2011 оноос олон улсын ISO 14001 Байгаль орчны менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэн амжилттай хэрэгжүүлсээр байна. Иймд удирдлага зохион байгуулалтын түвшинд дараах ажлуудыг төлөвлөлөө.

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хүлээгдэх үр дүн	Хугацаа	Зардал	Шаардлага
1	БОМТ-ны хэрэгжилтийг хангах, зохион байгуулах үүрэг бүхий дотоод хяналтын нэгж бүтцийг шинэчлэн, өргөжүүлэх	БОМТ-ний хэрэгжилтэнд ажилтан бүрийг хамруулж идэвхжүүлнэ.	I улирал	Цалин урамшууллын хэмжээ	Байгаль орчныг хамгаалаах тухай хууль, 31р зүйл
2	Жил бүрийн гүйцэтгэх ажлын хэмжээ болон зардлыг байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгаж ажиллана.	БОМТ хэрэгжилтэнд хяналтан тавих	IV улирал	-	Байгаль орчны хамгаалах тухай хууль
3	НУТ дотоод аудын хөтөлбөрийн дагуу Байгаль орчны хуваарьт аудит хийх	Байгаль орчны аудит хийж холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан хэрэгжүүлэх бөгөөд тайлангаа холбогдох газруудад хүргүүлнэ. Олон улсын SGS байгууллагаар аудитлагдана баталгаажуулна.	Жилийн турш	Дотоод үйл ажиллагаа	БОХТХ 31.2 /эрх бүхий байгууллагаас баталсан байгаль орчны холбогдолтой стандарт, хэм хэмжээ, дүрэм, журмыг чанд сахин биелүүлж, дотоодын хяналтыг хэрэгжүүлэх.
4	Тусгай зөвшөөрөлтэй эрх бүх байгууллагаар байгаль орчны аудит хийлгэх	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө: Байгаль орчны хуваарьт аудит хийлгэх	2024	Гэрээний дүн	БОНБҮТХ-10.11 Байгаль орчны аудитыг байгалийн нөөц, баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь хоёр жил тутам хийлгэж, холбогдох дүгнэлт, зөвлөмж гаргуулан



					хэрэгжүүлэх бөгөөд зөвлөмжид заасан хугацаанд тайлангаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд хүргүүлнэ
5	Онцгой байдлын ерөнхий газартай хамтран ажиллах гэрээ байгуулж гэнэтийн осол эрсдлийн талаар сургалт зохион байгуулах	Ажилчдыг гэнэтийн ослын үед цаг алдалгүй арга хэмжээ авах мэдлэгтэй болгох ба гэрээг тогтмол сунгаж ажиллана.	II улирал	Гэрээний дүн	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 4969 : 2000
6	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулах	Дүгнэлтийн хугацааг сунгасан байна.	I улирал	-	-
7	Химийн бодисын агуулахын дүгнэлт МХЕГ - аар	Химийн бодис хадгалалтын стандарт орчин, аюулгүй ажиллагаа бүрэн баталгаажна.	I улирал II	Гэрээний дүн	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах Ерөнхий шаардлага MNS 6458 : 2014
8	Бохир ус цэвэрлэх байгууламжийн технологи судлах, төслийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх	2-оос доошгүй технологийн судалгаа хийсэн байна.	Жилийн туршид	-	MNS4943:2015 хүрээлэн байгаа орчин, Усны чанар хаягдал усны ерөнхий шаардлага
9	Нийгмийн хариуцлагын хүрээнд: Байгаль орчинд ээлдээ арга хэмжээг төрийн болон хувийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	Байгаль орчинд холбогдох төслүүдийг хэрэгжүүлж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа хэрэгжүүлнэ.	Жилийн туршид	Гэрээний дүн	-
10	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, Мод тарих аян, их цэвэрлэгээ гэх мэт бусад аян үйл ажиллагаа зохион байгуулах	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэн, байгаль орчин дахь сөрөг нөлөөллийг бууруулна.	Хавар Намар	Гэрээний дүн	Хөрс хамгаалах, цөлжилтөөс хамгаалах тухай хууль

11	ISO 14001 БОМТ дэд багийн гишүүд менежерүүдийг стандарт, аудитор, мэргэжилтнүүдийн сургалтанд хамруулах	Ажилчдын чадавхи, мэдлэгийг дээшлүүлсэн байна.	Жилийн туршид	Үйл ажиллагааны дотоод сургалтын зардлаар	
12	Эрчим хүчний менежмент: Дулаан цахилгааны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах	Нэгж үйлдвэрлэлд хэрэглээг бууруулна.	Жилийн туршид	Дотоод үйл ажиллагааны зардал	
13	Усны нөөцийн менежмент: Усны алдагдлыг бууруулж, хэмнэлтийн баг үйл ажиллагаа, тоног төхөөрөмж, шийдлээр хэрэглээг багасган ажиллах	Нэгж үйлдвэрлэлд хэрэглээг бууруулна.	Жилийн туршид	Үйл ажиллагааны дотоод сургалтын зардлаар	MNS0900:2005 Хүрээлэн буй орчин, Ундны усны эрүүл ахуйн шаардлага
14	Хуваарийн дагуу олон нийтэд тайлагнах	БОМТ хэрэгжилтийн тайлан	Жилийн сүүлд	Дотоод үйл ажиллагааны зардал	БОМТ

### 3.2 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйлдвэрлэл үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд нөлөөлж буй болон болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, төг	Шалгуур үзүүлэлтийн үндэслэл
Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					

1	Орчны тоосжилт үүсэх, Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэж болзошгүй	Үйлдвэрийн гадна орчныг тохижуулах, зүлэгжүүлэх, тогтмол цэвэрлэж байх. Дулааны улиралуудад саарал усаар услах, дахин ашиглах цэвэрлэсэн усаар авто зогсоол болон бусад шороон зам талбайг услах	5-9.10 саруудад	-	
2	Нүүрсхүчлийн хий, хөргөлтийн бодис агаарт алдагдах, тэсэрч дэлбэрэхээс сэргийлэх	Техник тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянан ханган ажиллах	Жилийн турш	Үйл ажиллагааны зардал	
3	АтХ 9.1.2 Агаар хамгаалахтай холбоотой дүрэм, журам, бохирдуулах бодисын хаягдлын стандарт, хэм хэмжээний шаардлагыг хангах	Үйлдвэрлэлийн бүсэд суурилуулсан CO2 хэмжигч багаж тогтмол хянах эсэх ОХШХ-ийн дагуу жилд нэг удаа тогтоогдсон цэгүүд дээр агаарын шинжилгээ хийлгэдэг эсэх	Жилд нэг удаа	1,200,000	
4	Химийн бодисын хадгалалтын явцад асгарч алдагдсан тохиолдолд хортой аюултай хий ялгарах	Химийн бодисын агуулах дотор хяналтын камер болон хий илрүүлэгч суурин багаж байршуулах	Жилийн эхний хагаст	1,500,000	
<b>Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>					
5	Үйлдвэрийн хаягдал ус нь стандартын шаардлага хангахгүй байх	Үйлдвэрийн хаягдал усны чанарын шинжилгээ хяналтыг тогтмол хийлгэх. Өөрийн лабораторит сар бүр хийхээс гадна холбогдох итгэмжлэл бүхий лабораториор шинжилгээ хийлгэн, дүгнэлт гаргуулах	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан		“Усны тухай” хууль MNS 6561:2015 - MNS 4943: 2015 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиас 8.1.2
6	Төслийн хүрээнд усны нөөц ашиглах, хомсдох	Үйлдвэрийн цех бүрийн усны хэрэглээг нарийвчлан тооцох, нэгж бүтээгдэхүүнд зарцуулагдах усны нормыг хамгийн боломжит бага хэмжээнд байлгах -Усны нөөцийг хэмнэх, дахин ашигласан усны хэмжээ, хэрэглээг нэмэгдүүлэх	Жилийн турш	Сайжруулалтын багуудын нэмэлт урамшуулал	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 20.1.3

7	Усны нөөцийг дахин ашиглах, хамгаалах	Усны нөөцийг дахин ашиглах, хамгаалж ажлын хийж хэрэгжүүлэх.	Жилийн турш	Сайжруулалтын баг	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиас 8.1.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 20.1.3
8	Усны дүгнэлт гаргуулах	Усны тайлан улирралд гаргуулах, бохирдуулагчийн төлбөрийг улирлаар гаргах Усны газраас дүгнэлт гаргах	Улирал бүр	Гэрээний дүн	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиас 8.1.2 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 20.1.3
<b>Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө</b>					
9	Үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу хог хаягдал ил задгай үүсэх, хаягдлыг зайлуулалгүй удааснаар хөрс бохирдох	- Тусгай зөвшөөрөл бүхий байгууллагатай хатуу хог хаягдал шилжүүлэх устган зайлуулах гэрээ байгуулах, сунган ажиллах - хатуу хог хаягдлыг ангилан ялгах боломжтой шаардлага хангасан хогийн төв цэгийг дор бүр сайжруулж ажиллах - хог хаягдлыг тогтмол хугацаанд шилжүүлэх Нэгтсэн хогийн цэгийг сайжруулах ангилан ялгаж гэрээт байгууллад нийлүүлэх	Жилийн турш	хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	- Хог хаягдлын тухай хууль 9.2.2. 9.4.8 - Эрүүл ахуйн тухай хууль - MNS 5344:2003 - Хог хаягдлыг ангилан ялгаж хаях тухай журам -Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
10	Хөрсөн бүрхэвч элэгдэх, эвдрэх, зөөгдөх	Үйлдвэрийн нийт ногоон байгууламж бүхий талбайг тордон арчлах, услах, Машин техникийг тогтоосон зам талбайгаар явуулах	Жилийн турш	тодорхойлох боломжгүй	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
11	Хог хаягдлын менежментийн талаарх сургалт зохион байгуулах, хог хаягдлын ангилан хаялтыг нэмэгдүүлэх	Ажилчдын хог хаягдлын менежментийн талаарх суурь ойлголтыг дээшлүүлнэ.	Жилийн туршид	Үйл ажиллагааны дотоод зардлаар	Хогны тухай хууль, хог хаягдал ангилан хаях дотоод журам
12	Хог хаягдлын гэрээ сунгуулах, хамтран ажиллах байгууллагуудыг нэмэгдүүлэх	Хог хаягдлын гэрээг үргэлжлүүлэн сунгасан байна. Гэрээт болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалт өдөрлөг зохион байгуулах	Жилийн турш	Гэрээний дүн Дотоод үйл ажиллагааны зардал	Хогны тухай хууль, аюултай хог хаягдлын тухай хууль

13	Орчны сөрөг нөлөөллийг бууруулах	Нийт эзэмшил талбайн 10% -иас доошгүй талбайг зүлэгжүүлэх	II, III улиралд	1,500,000	-Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
14	Хатуу болон аюултай хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх	Хог хаягдлын зохих журмын дагуу зайлуулах	Жилийн турш	Гэрээний дагуу	БОАЖЯ-ын сайдын 2018 оны А/18 дугаар тушаалын 3.4 хавсралт
<b>Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө</b>					
15	Сөрөг нөлөөллөөс урьчдиглан сэргийлэх, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	“Ногоон соёлыг түгээх ажилчдын хашаанд мод тарих төслийн хүрээнд 300 м.кв тайлбайд мод тарин зүлэгжүүлэх	4 - 9 сар	Гэрээний дагуу	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
16		Үйлдвэрийн ногоон байгууламжийн жил бүрийн арчилгаа, үйлчилгээ, тохижилтыг сайжруулах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	3-10 сар	5,000,000 + Ажилчдын цалин урамшуулал	Газрын тухай хууль 56.6 Зүлэгжүүлэх талбай бэлдэх, үр тарих арчлах MNS6260:2011
17		“Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөний хүрээнд Горхи-Тэрэлж байгалийн цогцолбор газарт мод тарих	6 - 9 сар	5,000,000	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Тодорхойлогдсон нийт:				<b>9,700,000</b>	

### 3.2.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
<b>Агаарын чанарын хяналт шинжилгээ</b>								



1	Агаарын чанар- NO2, SO2, нийт тоосны агуулам	Нийт 4 цэгт: Үйлдвэрийн гадна ба дотор орчин - Үйлдвэрийн урд болон хойд хэсэгт, - Агуулахуудын дотор хэсэгт	Жилд нэг удаа	1	869.000	869.000	Nart consulting итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлнэ.	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ажлын байрны орчин зөвшөөрөгдөх дээд хэмжээ
2	Дуу чимээ - Дотоод орчны дуу шуугианы түвшин	Нийт 6 цэгт: Үйлдвэрийн цехүүдэд (Нэрийн архи савлах, ус ундаа савлах, найрлага бэлдэх, пиво савлах, архи савлах цех)	Жилд нэг удаа	6	18,000	108,000	Байгаль орчны Хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлнэ.	MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
<b>Усны чанарын хяналт шинжилгээ</b>								
3	Төвлөрсөн ус хангамжийн усны чанарын шинжилгээ	Үйлдвэр тус бүрийн авч буй ус /12/	Сар бүр	4	96000	384,000	АПУ төв лабораторид шинжлэнэ.	MNS 0900:2018 Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ.
4	Нийлүүлэх хаягдал усны шинжилгээ	Ариутгах татуургын шугамд орохын өмнөх хэсгээс эсвэл үйлдвэр тус бүрийн хаягдал ус гаргах хэсгээс	Улиралд	4	96,000	384 000	АПУ төв лабораторид шинжлэнэ. Мөн УСУГ -ын төв лабораторид жилд нэг удаа шинжлүүлнэ.	MNS6561:2015 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усанд тавигдах ерөнхий шаардлага
<b>Хөрсөн бүрхэвчний хяналт шинжилгээ</b>								
5	Хөрсний чанар- Хими физикийн ерөнхий үзүүлэлтүүд	Нийт 4 цэгт: 1. Хог хаягдлын цэгийн орчимд, 2. Үйлдвэрийн ногоон байгууламж орчим, 3. Ауруг авто зогсоолын орчим, 4. Агуулахын байр орчим	Жилд нэг удаа	1	500,000	500,000	Эрдэс судлалын Хан Лаб лабораторид шинжлүүлнэ.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд

6	Хөрсний чанар - Хүнд металлууд	Нийт 4 цэгт: 1. Хог хаягдлын орчимд, 2. Үйлдвэрийн ногоон байгууламж орчим, 3. Ауруг авто зогсоолын орчим, 4. Агуулахын байр орчим	Жилд нэг удаа	1	1,400,000	1,400,000	Эрдэс судлалын Хан Лаб лабораторид шинжлүүлнэ.	MNS 3298:1990 Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд, MNS 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Тодорхойлогдсон нийт:						<b>3.645.000</b>		

### 3.3 Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Химийн бодисын хадгалалтад Монгол Улсын хууль, дүрэм журмууд болон компанийн дотоод журам болох химийн бодисын хяналтын тухай журмын дагуу хяналт тавин ажиллаж байна. Компанийн хэмжээнд нийт 233 нэр төрлийн химийн бодисыг төв лаборатори болон үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглаж байна. Үйлдвэрийн технологи болон тоног төхөөрөмжийн угаалга цэвэрлэгээнд ашиглах бодисуудыг “Soruga” олон улсын компанийн бодисыг хэрэглэдэг ба лабораторийн хэрэгцээний химийн бодисуудыг дотоодын компаниудаас худалдан авдаг. Бодисуудын сав, баглаа боодол бүрэн бүтэн эсэхийг шалган тээвэрлэх бөгөөд бодисууд нь хоруу чанар багатай, тогтвортой шинж чанартай. Хадгалалтын хувьд химийн бодисуудыг “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага. “MNS 6458:2014”- ийн шаардлага хангасан агуулахад хадгалах журмын дагуу ангилан, нэр хаяг, шошго, анхааруулах үг, тэмдэг тэмдэглэгээ, хор аюулын мэдээллийг байршуулан хадгалах тул санамсаргүй осол, эрсдлээс бусад тохиолдолд сөрөг нөлөө бага. Үйлдвэр үйл ажиллагааны хүрээнд ашиглаж буй бүх химийн бодисыг ХАЛМ-тай байлгаж бүртгэлжүүлэн ажиллаж байна. Бодисууд нь 25-200кг болон 20-200л-ийн хэмжээ шуудай, хуванцар савлагаатай.

№	Болзошгүй аюул, осол, эрсдэл үүсч болохуйц үйл	Болзошгүй аюул, осол, эрсдэл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Баримтлах стандарт, аргачлал
---	--	------------------------------	--	------------------------------

ажиллагаа				
1	Химийн хорт болон аюултай бодисыг тээвэрлэх	Химийн хорт болон аюултай бодис асгарах	Химийн бодисыг тухайн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, химийн бодис асгарсан, онцгой үед хэрэглэх багц, шингээгч материалыг зохих газруудад байрлуулах	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2 дугаар бүлэг,
		Эрсдлийн болон тээвэрлэлтийн үед авах арга хэмжээг мэдэхгүйн улмаас аюул осол гаргах, эрсдлийн нөлөөллийг ихэсгэх	Тээвэрлэлт хийж буй жолооч нарыг сургалтанд хамруулж, химийн бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаарх мэдлэг олгох	
		Химийн бодисыг тээвэрлэлт хийх нөхцлийг хангахгүй байх	Химийн бодисыг тээвэрлэхдээ сав баглаа боодлын бүрэн бүтэн байдлыг ханадаг байх, асгарч алдагдсан тохиолдолд хураан авах саармагжуулах, хоргүйжүүлэх материал, гал унтраах багаж хэрэгслээр тээврийн хэрэгслийг тоноглох	
2	Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах	Химийн бодисын агуулахын стандарт нөхцлийг хангаагүйн улмаас аюул осол, эрсдэл үүсгэх	Химийн бодисуудыг битүүмжлэл сайтай хуурай, сэрүүн, агааржуулалт сайтай агуулахад бодисын хор аюулын мэдээлэлд заасны дагуу хадгалах	Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах Ерөнхий шаардлага MNS 6458 : 2014, Үйлдвэрийн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны компанийн дотоод журам
			Химийн бодисын агуулахыг стандартын дагуу тохижуулах, агуулахыг орчим ил гал гаргах, тамхи татахгүй байх	
			Химийн бодис асгарч, алдагдах, ажиллагсад хордох, бэртэх, гэмтэх, галын аюулын үед бодисыг хураан авах сав, хүрз хоргүйжүүлэх саармагжуулах бодис урвалж, яаралтай тусламжийн эмийн сан, гал унтраах багаж хэрэгсэл бэлэн байлгах	
